

Аймгийн Засаг даргын 2024 оны 05  
дугаар сарын 06 –ны өдрийн A/161  
дугаар захирамжийн 1. дүгээр  
хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН  
ХҮРЭЭНИЙ АГЕНТЛАГУУД, СУМДЫН ЗАСАГ ДАРГА,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЯВЦЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙЖ,  
ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ АЖЛЫН УДИРДАМЖ

2024 оны 05 дугаар сарын 06

Чойр хот

НЭГ. ЯВЦЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Аймгийн эрхлэх асуудлын хүрээний агентлагууд, сумдын Засаг дарга, засаг даргын Тамгын газрын 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажил нь бүх шатанд ажлын хариуцлага сахилгыг өндөржүүлэх, санаачлагыг өрнүүлэх замаар амжилтыг бататгах, хүндрэл бэрхшээлийг арилгаж иргэдэд үйлчлэх, төрийн үйлчилгээнд чанарын ахиц дэвшил гаргах, бодлогын зорилтууд, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулахад оршино.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛТ

- Бодлогын баримт бичгүүд, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, захиргааны байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилт, тайлагналт.
- Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны явц, үр дүн, түүний ашиглалт хамгаалалт.
- Төрийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, бодлогын зорилт зохих үр дүн, түвшинд хүрч хэрэгжээгүй буюу гажуудал гарсан бол өөрчлөн залруулах, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", аймгийн Засаг даргын 2021 оны A/147 дугаар захирамжаар батлагдсан "Баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ыг тус тус эрх зүйн үндэс болгоно.

ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

- Бүх байгууллагын үйл ажиллагаанд дараах чиглэлээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Үүнд:

4.1.1. Үйл ажиллагааны хүрээнд 2024 оны хагас жилд хийсэн ажлын талаарх мэдээллийг 10-15 минутанд багтааж мэдээлэх.

4.1.2. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт.

4.1.3. Засгийн газрын гишүүнээс аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт.

4.1.4. Аймгийн Засаг даргаас төсвийн шууд захирагчтай байгуулсан гэрээний үүргийн биелэлт

4.1.5. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт

4.1.6. Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ

4.1.7. Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ

4.1.8. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын хэрэгжилт

4.1.9. Байгууллагын төсөв санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдал, Шилэн дансны хуулийн хэрэгжилт, Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл.

4.1.10. Төрийн албаны стандарт /байгууллагын бүтэц зохион байгуулалт, орон тоо, чиг үүргийн давхардал, ажлын байрны тодорхойлолт, төрийн албан хаагчийн томилгоо, хувийн хэргийн бүрдэл, төрийн албан хаагчидтай байгуулсан гүйцэтгэлийн гэрээ, хөдөлмөрийн гэрээ, түүний хэрэгжилт, үнэлж дүгнэсэн байдал.

4.1.11. АИТХ-ын тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, албан хэрэг хөтлөлт, өргөдөл гомдол, хариутай бичгийн хэрэгжилт

4.1.12. Аймгийн УАШЗ-өөс өгсөн үүрэг даалгавар, түүний гүйцэтгэл

4.1.13. 2024 оны хагас жилийн хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилт үр дүнгийн тайлагналт, хяналт-шинжилгээ үнэлгээний ажлын үр дүнд.

4.2. Сумдын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд 4.1-т заасан чиглэлээс гадна дараах чиглэлийг хамруулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Үүнд:

4.2.1. Сумын Засаг даргаас багийн Засаг дарга болон төсвийн байгууллагын захирал, эрхлэг нартай байгуулсан гэрээний үүргийн биелэлт

4.2.2. Багийн Засаг дарга нарын үйл ажиллагаанд (мэдээ, тайлан, анхан шатны судалгаа, баримт бичгийн хөтлөлт)

4.2.3. Хангалтгүй тайлагнасан арга хэмжээний үнэлгээ буурч үнэлэгдэх тул үнэн зөв, чанартай, тоон мэдээллийн алдаагүй, арга хэмжээний хүрэх түвшин шалгуур үзүүлэлтэд бүрэн нийцсэн, 2000 тэмдэгтэд багтаан тайлагнахыг анхаарах.

ТАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХАМРАГДАХ ХҮРЭЭ, ХУГАЦАА

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 35 агентлаг, Баянтал сумын ЗДТГ, баг, Шивээговь сумын ЗДТГ, баг, Сүмбэр сумын ЗДТГ, багууд тус тус хамрагдана.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хэсэг 2024 оны 05 дугаар сарын 20-оос 05 дугаар сарын 31-ний өдрүүдэд байгууллагуудын үйл ажиллагаатай танилцан батлагдсан хуваарийн дагуу үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

#### ЗУРГАА. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

6.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсэг тайлан дүгнэлтээ нэгтгэн аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулна.

6.2. Агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газар, багуудын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ ажлын хэсэг бүрэн бүрэлдэхүүнээрээ ажилана.

6.3. Агентлаг, сумдын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын үр дүн, дүгнэлт зөвлөмжийг ажлын хэсэг багаар хэлэлцэн гаргах бөгөөд дүгнэлтэнд ажлын хэсгийн ахлагч болон гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна. Дүгнэлтийн бодит байдлыг тухайн ажлын хэсэг хариуцана.

6.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх ажлын хэсгийн гишүүд чиглэл бүртээ тухайн байгууллагын хийсэн ажлын ололт амжилт, алдаа дутагдал, анхаарах зүйлс, цаашид авч хэрэгжүүлэх ажлуудын талаар илтгэх хуудсандаа бичиж, нэгдсэн зөвлөмжинд тусгаж танилцуулна.

**Жич:** Байгууллага бүр удирдамжийн дагуу тайлан, мэдээний биелэлт, хэрэгжилтээ гаргасан байх. Хуваарийн дагуу очиход гараагүй тайлангийн үнэлгээг "0" үнэлгээгээр үнэлэхийг анхаарна уу.